

Зааратай хамт залбирсан нь

Шэррий Гавин

Бодит түүхээс сэдэвлэв

Зуны аагим халуун орой Рийси, Шайен хоёр Заараг хамт тоглоё гэж урьжээ. Ээж нь хөнгөн зууш бэлдэв. Охид зууш идэхээр ширээний ард суулаа.

Ээж мангоны модноос манго авч зүсээд, мөн тавган дээр зүсэж хэрчсэн алим болон усан үзэм тавилаа. Рийси амтат зууш руу хараад, идэхээсээ өмнө залбирах ёстой гэдгээ санав. Тэр Заарагаас “Чи гэртээ залбирдаг уу?” гэж асуув.

“Тэр чинь юу юм бэ?” гэж Заара асуув.

“Ингэж хийдэг юм” гэж Шайен хэлээд, гараа энгэртээ зөрүүлэн, толгойгоо бөхийлгөв. Тэр хоолыг адисалж өгөхийг хүслээ. Тэр залбирч дуусаад, “Харж байна уу? Яг л үүн шиг амархан” гэж хэлэв.

“Бид гэртээ үүнийг хийдэггүй. Бид шууд л идчихдэг” гэж Заара хэллээ.

Рийси хэзээ ч *залбирахгүй* байх тухай бодож байсангүй. “Ээж ээ, бид залбирахаа больж болох уу?”

Ээж нь инээмсэглэн, мөстэй аяга

барьсаар ширээн дээр ирэв. “Бид Тэнгэрлэг Эцэгийн бидэнд өгсөн зүйлийн төлөө талархлаа илэрхийлэх дуртай. Бид залбирсаар байх болно. Гэхдээ бусад хүн залбирахгүй байгаад санаа зовох хэрэггүй.”

Рийси ээжийнхээ зөв гэдгийг мэдэж байв. Гэр бүлээрээ залбирахад тэр аз жаргалтай *байдаг*. Залбирал Заараг ч жаргалтай болгож болно. “Чи ч бас оролдоод үзээрэй” гэж тэр Заарад хэллээ.

“Залбирах нь сайн зүйл.”

“Биднийг залбирахад би дуртай” гэж Шайен хэллээ. “Энэ нь намайг аз жаргалтай болгодог.”

Заара инээмсэглэв. “Би залбирч магадгүй” гэж тэр хэлээд, мангогоо идлээ.

Рийси, Шайен хоёр залбирлын тухай найздаа хэлсэндээ баяртай байсан юм. Тэд зуушаа идэж дуусаад, тоглохоор гадагш гарч гүйлээ. ■

Зохиогч нь Австралийн Квийнслэндэд амьдардаг.

